



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

ЭДЭЭ

№91 /535/

2023.06.06

Цаг үе, үйл явдал

АХЛАГЧ НАР ЧУУЛЛАА



Монгол Улсын Зэвсэгт хүчинд мэргэжлийн ахлагч бэлтгэж эхэлсний болон ҮБХИС-ийн Батлан хамгаалах мэргэжлийн сургалт-Үйлдвэрлэлийн төв үүсэн байгуулагдсаны түүхт 30 жилийн энэ онд тохиож байна.

Уг түүхт ойн хүрээнд ахлагч мэргэжлээрээ овоглож Монгол Улсын Зэвсэгт хүчний гол цөмийг бүрдүүлж буй ахлагч нар чуулж баярын хурлаа зохион байгууллаа. Баярын хуралд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар тэргүүтэй хүндэт зочид болон БХЯ, ЗХЖШ, Төрийн цэргийн командлал, Төрийн цэргийн

Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хэлсэн үгэндээ Батлан хамгаалах салбар, Монгол Улсын Зэвсэгт хүчин, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын 70 гаруй хувийг, олон улсын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй нийт бие бүрэлдэхүүний 80 гаруй хувийг ахлагч нар бүрдүүлж байна. Орчин үеийн дэлхийн улс орнуудын Зэвсэгт хүчний хөгжлийн чиг хандлага нь шилдэг технологид суурилсан зэвсэглэл, техникийн хөгжил, түүнийг эзэмшигч мэргэжлийн өндөр ур чадвартай ахлагчтай байх нийтлэг шинжтэй болсон. Иймээс мэргэжлийн цэрэгт

харамгүй дайчлан ажилладаг талархаж явдгаа илэрхийлсэн юм.

Ташрамд дуулгахад ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба нь 2001-2006 онд "Ахлагч бэлтгэх төв", "Ахлагчийн сургууль", "Ахлагчийн коллеж"-д ротын захирагчийн албан тушаалыг хашиж явсан ахлагчийн сургуулиараа овоглогч нэгэн билээ.

Түүхэн ойн хүрээнд батлан хамгаалах салбар, Монгол Улсын Зэвсэгт хүчинд хөдөлмөр зүтгэл, залуу насаа зориулсан ахмадууд болон өдгөө үр



болон хууль сахиулах байгууллагын удирдлагын төлөөлөл, ахлагчийн сургуулийн үе үеийн удирдлага, ажилтан, албан хаагчид, төгсөгчид оролцлоо.

Энэ үеэр Ерөнхийлөгчийн Тамгын газрын төрийн цэргийн байгууллагын асуудал хариуцсан ахлах референт хурандаа Т.Буянбат Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн мэндчилгээг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулсан юм.



суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчний хөгжүүлэх бодлого, зорилтыг хангах бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бие бялдар, сэтгэл зүйн өндөр бэлтгэлжилт бүхий мэргэжлийн ахлагчийг сургаж бэлтгэхэд Зэвсэгт хүчний үндсэн цөм болсон ахлагч нарын хичээл зүтгэл, оролцоо ихээхэн чухал болохыг онцлон тэмдэглэсэн юм.

Мөн энэ үеэр ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба баяр хүргэж хэлсэн үгэндээ ҮБХИС-ийн Батлан хамгаалах мэргэжлийн сургалт-Үйлдвэрлэлийн төвийг үүсгэн байгуулах, хөгжүүлж, бэхжүүлэх бахдам үйлсэд оюун ухаан, хөдөлмөр зүтгэлээ зориулсан үе үеийн удирдлага, эрдэмтэн багш, төгсөгч, сонсогчдоо түүхт 30 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлээд Монгол Улсын Зэвсэгт хүчин хуулиар хүлээсэн үндсэн болон бусад чиг үүрэг, төр засгаас хүлээлгэсэн улс орноо батлан хамгаалах хариуцлагатай бөгөөд хойшлуулшгүй үүргээ ёсчлон биелүүлэх Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг тууштай хэрэгжүүлэхэд ахлагчийн нийт бие бүрэлдэхүүн, мэдлэг боловсрол, бие сэтгэл хичээл зүтгэлээ

бүтээлтэй ажиллаж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим тэргүүний ахлагч нарыг Батлан хамгаалах салбарын шагналаар шагнаж урамшууллаа.

Арга хэмжээний төгсгөлд ЦДБЭЧ-ын уран бүтээлчид цэрэг эх орны сэдэвт урлагийн тоглолтоо өргөн барьж олон түмний мэлмийг баясгасан юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 21 | 🌧️ 11 |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 35 | 🌧️ 25 |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ | ЗАРАХ |
|--------|-------|-------|
| USD 🇺🇸 | 3,441 | 3,448 |
| EUR 🇪🇺 | 3,715 | 3,730 |
| CNY 🇨🇳 | 486 | 488 |
| RUB 🇷🇺 | 41.60 | 42.20 |
| JPY 🇯🇵 | 24.95 | 25.15 |
| KRW 🇰🇷 | 2.62 | 2.64 |

ЗУРХАЙ

2023.06.06 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 17

ЗУНЫ ТЭРГҮҮН УЛААГЧИН МОГОЙ САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өнгө зүс доройтно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

04.55-20.46

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 689,943,620

Эдгэрсэн

Нийт: 6,887,839

Нас барсан

Нийт: 662,385,270

Цахим шууданд

ХАМТАРСАН СУРГАЛТ, ДАДЛАГЫН НЭЭЛТ БОЛЛОО



Клаус Ломанс, ХБНГУ-ын Зэвсэгт хүчний сургалтын хөдөлгөөнт бүлгийн дарга дэд хурандаа Прэссентин нар болон сургалт дадлагад оролцож байгаа хоёр улсын цэргийн алба хаагчид оролцсон юм.

Энэ үеэр ЗХЖШ-ын АУГ-ын дарга хурандаа Д.Дугаррагчаа хэлсэн үгэндээ "1993 оноос эхэлсэн Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын цэргийн хамтын ажиллагаа жилээс жилд өргөжин хөгжиж байгаа бөгөөд энэ удаагийн хамтарсан сургалт, дадлага нь манай Зэвсэгт хүчний цэргийн инженерийн мэргэжлийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхийн сацуу даян дэлхийн энхийн төлөөх Монгол Улс-ХБНГУ-ын ирээдүйн цэргийн хамтын ажиллагааны нэгэн гол чиглэл болно гэдэгт бид итгэлтэй байна" гэдгийг онцоллоо.

Мөн ХБНГУ-ын Зэвсэгт хүчний Сургалтын хөдөлгөөнт бүлгийн дарга дэд хурандаа Прэссентин "Бидний сургалтын гол зорилго нь Монгол Улсын Зэвсэгт хүчний дараагийн төлөвлөгөөт НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний ажиллагааны өмнөх бэлтгэлд үнэтэй хувь нэмэр оруулахад оршино" гэдгийг тодотгосон юм.

Энэхүү нээлтийн ёслолын ажиллагааны төгсгөлд ЦДБЭЧ-ын бие бүрэлдэхүүний уран бүтээлийн тоглолтыг өргөн барилаа.

Монгол Улсын Зэвсэгт хүчин Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Зэвсэгт хүчний Сургалтын хөдөлгөөнт бүлэгтэй хамтарсан сургалт, дадлагын нээлтэд зориулсан ёслолын ажиллагааг 6 дугаар сарын 6-ны өдөр Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн байрлалд зохион байгуулав.

"Тээврийн хэрэгсэлтэй эргүүл хийх үеийн гар хийцийн тэсрэх бөмбөгийн аюул, заналхийллээс сэрэмжлэх, хяналт үйлдэх" сэдэвт энэхүү сургалт, дадлагын нээлтийн ёслолд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга хурандаа Д.Дугаррагчаа, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга хурандаа Б.Буяндэлгэр, Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаатар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга Михаэль Россбах, ХБНГУ-ын Батлан хамгаалах яамны бие төлөөлөгч

ХОЁРДУГААР ШАТНЫ ҮЗЛЭГ ЭХЭЛЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэгийн хоёрдугаар шат өнөөдөр (2023.06.06)-өөс эхэлж байна.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, дүрэмч-жагсаалч байдал, сэтгэл зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин, цэргийн сургалт бэлтгэлийн явц, чанар, орчин, өнөөгийн байдлыг бодитоор тогтоож, цаашид цэргийн алба хаагчдад чиглэсэн сургалт бэлтгэлийг сайжруулах арга замыг оновчтой тодорхойлох зорилгоор энэхүү үзлэгийг 3 үе шаттайгаар зохион байгуулж буй юм.

Энэхүү хоёрдугаар шатны үзлэгийг ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон дэд ажлын хэсэг 6 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байгаа бөгөөд уг дэд ажлын хэсэг нь батлагдсан ерөнхий удирдамжийн дагуу, тогтоосон хугацаанд мэргэжлийн арга зүйгээр хангахад чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж, үзлэгийг шударга, нээлттэйгээр зохион байгуулж, цаашид офицер, ахлагчийн

албыг хөгжүүлэх, чадваржуулахад чиглэгдсэн бодлогыг тодорхойлон Ажлын хэсэгт тайлагнах үндсэн үүргийг хүлээх ажээ.

Ийнхүү Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэгийн хоёрдугаар шат эхэлж буй эхний өдөр Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн офицер, ахлагч нар бүрэн бүрэлдэхүүнээр хамрагдлаа.

Мөн энэ сарын 7-ны өдөр ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн алба хаагчид хамрагдах ба цаашид батлагдсан хуваарийн дагуу үзлэг үргэлжилнэ.

Тодруулахад, энэхүү түвшин тогтоох үзлэгийн нэгдүгээр шатны шалгаруулалтыг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд батлагдсан удирдамжийн дагуу дотооддоо зохион байгуулж, дүнгээ ирүүлсэн ба офицер, ахлагчийн албан тушаалд ажиллаж буй алба хаагчдыг 100 хувь хамруулсан юм.

Хурандаа
Б.ОТГОНБАЯР
Гэрэл зургийг хошууч
Э.ГАНБАЯР

ХОЁР ДАХЬ УДААГИЙН ТӨГСӨЛТИЙГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



ЗХЖШ-ын даргын 2023 оны А/39 дүгээр тушаалаар Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дэргэдэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын төвийн хоёр дахь удаагийн төгсөлтийг энэ сарын 5-ны өдөр зохион байгууллаа.

Энэ үеэр төгсөгчдийн сертификатыг Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга хурандаа Х.Батсайхан мөн газрын даргын орлогч, штабын дарга хурандаа Ж.Баясгалан, Ерөнхий инженер, хэлтсийн дарга хурандаа Д.Энхцог нар гардуулсан юм.

Сургалтад ЗХЖШ-ын Зохион байгуулалтын бүтцийн нэгж, төрлийн

цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан 55 мэргэжилтэн хамрагдаж, 43 алба хаагч амжилттай төгслөө.

Уг сургалтыг 14 хоногт багтаан вакуумжуулсан хэлбэрээр зохион байгуулсан нь онцлог байв.

Цаашид тус сургалтын төв нь 2023 оны 3, 4 дүгээр улиралд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтнүүдийн мэргэшүүлэх сургалтыг хоёроос гурван удаа зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Хошууч Б.ХИШИГБАЯР

"37 ЖИЛИЙН ДАРАА ОЛДСОН ААВЫНХАА ЗАХИДЛААС ЦЭРГИЙН АЛБАНЫ САЙХНЫГ МЭДЭРЛЭЭ"



аавынх нь эр цэрэгт байхдаа бичсэн захидал олдож, дахин уулзсан юм шиг л боллоо гээд баярлаад сүйд. Миний аав гурван жилийн цэрэг. Алба хааж байхдаа дүү нартаа байнга захидал бичиж, цэргийн албаныхаа сайхныг дурсаж, нутаг орны сонин сайхныг асуудаг байсан гэнэ лээ. Халагдаж ирээд ээжтэй минь танилцаж, 1991 онд миний бие, 1998 онд дүү Гүнж төрсөн. Аав минь жирийн нэгэн ажилчин хүн байв. Хэдий сургууль соёлын мөр хөөгөөгүй ч захидал сайхан бичнэ, ном сонин их уншдаг хүн байсан сан. Хүүхэд байхад байнга цэргийн алба тэр дундаа нөхөрлөлийн тухай ярина. Тэр бүрт нь анхаарч сонсоогүй, төдийлөн ач холбогдол өгч байгааг үйдээ одоо харамсдаг юм. Хүүхэд байсан болохоор цэрэг, цэрэг гэдэг яриа ч нэг их сонин биш байсан байх. Захидлын эзэн нь таны авга эгч юм байна тийм үү?

-Тийм ээ, Нанзадын Долгоржав гэдэг, өдгөө Дундговь аймгийн Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлаар ажилладаг. Түүрхэн хэлсэнчлэн аав минь эрдэм мэдлэгийг дээдэлж, цэргийн албаараа бахархаж, орон нутгаа шүтдэг хүн байж билээ. Ахан дүүс, үр хүүхэд нь цөмөөрөө Дундговь аймагтаа ажиллаж амьдарч байна. Ямар сайндаа охин, хүү хоёрыгоо хэд хэдэн их сургуульд сургаж, орон нутагтаа ирж ажилла гэдэг байсан болохоор миний бие өдгөө Дундговь аймгийн ЗДТГ-т гадаад харилцааны мэргэжилтнээр ажилладаг. Гэхдээ яг одоо бол БНСУ-д хөтөлбөрт хамрагдан суралцаж байна. 10 дугаар сард нутаг буцна.

Эжэ Д.Аюушсүрэн Дундговь аймгийн Эрдэнэдалай сумынхаа Эрүүл мэндийн төвийн үйлчилгээнд нь мөн л насаараа ажиллаж яваа эмэгтэй. Аав минь бурханд дэвшээд хоёрхон жил болж байгаа болохоор бичсэн захидал нь манай гэр бүлд дахин уулзсан юм шиг баяр баясгалан, сэтгэл хөдлөлийг авчирлаа. Аавыгаа эх орныхоо шилдэг цэрэг нь байж, халагдсаныхаа дараа ч нутгийн зон олондоо албаа магтаж, бахархаж сууснаар нь бид үргэлж дурсах болно. Цэргийн алба гэдэг эр хүн бүрийн бахархал гэдгийг нь хожим ч гэсэн аавынхаа захидлаар дамжуулж ойлгосондоо талархаж байна. Аавын минь захидлыг олсон, авчирч өгсөн хилчин дайчдадаа баярлалаа.

Ахмад
Д.БОЛОР

Эр цэргийн албаа хааж байсан байлдагчийн хайрт дүүдээ бичсэн захидал 37 жилийн дараа олдож, нандин түүхийн хуудсаар уншигч олныг эргүүлэв. Захидлын эзэн тэнгэрт дэвшиж, "Ах нь дүүгээсээ захидал их харсан шүү" хэмээн хаягласан долоодугаар ангийн охин дүү нь өдгөө боловсролын салбарт насаараа ажиллаж яваа багш гэдгийг нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр олж мэдэв. Эр цэргийн алба гэдэг эр хүн бүрийн насны бахархал, санаж дурсах мөнхийн сэдэв. Тэртээ 1986-1989 онд Хилийн цэргийн 0131 дүгээр ангид хугацаат цэргийн алба хааж, бичиж байсан захидлаараа нийгэмдээ дахин "дурсагдаж" яваа эрхэм байлдагч Нанзадын Болдын охин Адъяатай ярилцсанаа хүргэе. Үүний өмнө ярилцагчийнхаа тухай товчхон мэдээлэл хүргэхэд тэрээр Монгол Улсын төрийн албаны ерөнхий шалгалтын анхны дээд амжилтыг үзүүлсэн хоёр хүний нэг. Түүхэн амжилтаараа төрийн аль ч байгууллагад ажиллах боломж нь түүний өмнө байгаа ч гэр бүлээрээ төрөлх нутагтаа ажиллаж амьдрах нь түүний зорилго. Нутаг орноо гэсэн сэтгэл нь түүний ааваасаа хүмүүжил гэнэ лээ. Таны аавын захидал олджээ. Сайхан санагдаж байгаа байх даа ...

-Тэгэлгүй яах вэ. Ээж минь

